

Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тухай зар

Админ 2023-09-13 916

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;

- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/.

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 17.00 цаг хүртэл

Хүлээн авах хаяг : Жагсаалтад бүртгэлтэй тухайн төрийн байгууллагын цахим шуудангаар бичиг баримтаа бүрэн бүрдүүлэн илгээнэ.

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛД ШИЛЖҮҮЛЭН АВАХ АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Сул орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод				Утас Цахим хаяг
					Төрөл	Ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага	
1	Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	Үйлчилгээний тасаг	Тэтгэврийн байцаагч	1	Төрийн захиргаа	ТЗ-7	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-Нягтлан бодох бүртгэл /041101/ -Санхүү /041201/ -Даатгал /041201/ -Эдийн засаг /031101/ -Менежмент ба удирдахуй /041301-041304/	“Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх” гэснийг хассугай. ТАЗ- 2023.03.21-ний 90 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон.	Туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан бол давуу тал болно.	orhon@ndaatgal.mn 99170005, 99262089
2	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	Барилга, хот байгуулалтын хэлтэс	Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	Төрийн захиргаа	ТЗ-9	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-Архитектур, хот төлөвлөлт/073102, 073103/ -иргэний ба үйлдвэрийн барилга, байгууламж /0732/ -цахилгаан эрчим хүч /071302, 071303, 071304, 071305/ -халаалт, агаар сэлгэлтийн инженер -ус хангамж, ариутгах татуургын инженер	“Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх” гэснийг хассугай. ТАЗ- 2023.03.21-ний 90 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон.	Туслах түшмэлийн албан тушаалд эсхүл мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажилласан байх.	orkhon@gazar.gov.mn 99903884

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ